

**ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХ, АРБИТРТ ХЭРЭГ, МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ  
МЭДЛЭГИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВРЫН ГҮЙЦЭТГЭЛ, ДҮГНЭСЭН АРГАЧЛАЛ**

№	Шалгах үзүүлэлт	Даалгаврын гүйцэтгэл	Өгөх үнэлгээ
1	<b>Давж заалдах гомдол гаргахад хуулиар тогтоосон хэлбэр, агуулгын шаардлагыг хангасан байдал</b> <i>(ИХШХШтХ-ийн 162 дугаар зүйлийн 162.2 дахь хэсэг)</i>		
	- гомдлыг ямар шүүхэд гаргаж байгааг даалгаврын өгөгдөлд нийцүүлэн зөв бичсэн эсэх	<b>НИЙСЛЭЛИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХЭД</b>	
	- гомдол гаргагч этгээдийн мэдээллийг хуульд заасан шаардлагын дагуу бичсэн бүрэн тусгасан эсэх	Гомдол гаргагч:Нэхэмжлэгч ... овгийн ...-ийн С-ийн өмгөөлөгч ...-ийн ... Хаяг: ... дүүргийн ... дугаар хорооны, ... тоот	
	- аль шүүхийн ямар шийдвэрийг давж заалдаж байгааг даалгаврын өгөгдөлд тусгаснаар зөв бичсэн эсэх	Нэхэмжлэгч С өмгөөлөгч миний бие Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн ... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаартай шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах гомдлыг гаргаж байна.	0-3
	- гомдлын үндэслэлийг ялгагдахаар тодорхой тусгасан эсэх	Шалгах үзүүлэлтийн 2	
	- гомдлын шаардлага буюу давж заалдах шатны шүүхэд гаргаж байгаа хүсэлтээ тодорхой, ялгагдахаар бичсэн эсэх	Шалгах үзүүлэлтийн 3	
2	<b>Гомдлын хууль зүйн үндэслэлийг тодорхойлсон байдал</b>		
	- шүүхийн шийдвэрийг бүхэлд нь, эсхүл түүний ямар үндэслэл, заалтыг зөвшөөрөхгүй байгааг дэлгэрэнгүй, тодорхой оновчтой зөв тодорхойлсон эсэх.	<b>Гомдлын үндэслэл:</b> Миний үйлчлүүлэгч С нь Б-тэй 2006 онд танилцан гэр бүл болж, 2012 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр бүртгүүлэн түүнийг нас барах хүртэл 15 жилийн хугацаанд хамтдаа амьдарч байсан болох нь тэдний гэрлэлтийн баталгаа, оршин сууж байгаа хорооны ам бүлийн тодорхойлолт зэрэг баримтуудаар тогтоогдож байгаа. Тэдний дундаас 2007 онд охин М, 2020 онд хүү Э нар төрсөн. Нөхөр Б маань 2021 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр гэртээ гэнэтийн өвчнөөр нас барсан. Талийгаач Б нь хэд хэдэн банкинд хадгаламжтай байсан ба их хэмжээний мөнгө хадгалуулсан байсан. Баянзүрх дүүргийн ...-р хороонд байрлах “Цээнэ” худалдааны төвийн 201 тоотод үйл ажиллагаа явуулдаг Нийслэлийн тойргийн нотариатч Н нь 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдөр 0008 дугаартай өвлөх эрхийн гэрчилгээр манай нөхөр Б-ийн Хаан банкны ... тоот төгрөгийн данс дахь 20,000,000 төгрөгийг хүүгийн хамт, 0009 дугаартай өвлөх эрхийн гэрчилгээр Б-ийн ХХБ дахь 6 дансан дахь нийт 70,000 америк долларыг, хүүгийн хамт тус тус түүний эцэг болох П-д 100 хувь өвлүүлсэн байдаг. Нотариатч Н нь өвлүүлэгчийн эцэг П-д өвлөх эрхийн гэрчилгээ олгохдоо өвлүүлэгч Б-ийн хууль ёсны эхнэр С болон насанд хүрээгүй охин М, бага насны хүү Э нарын талаар холбогдох лавлагаа мэдээллийг эрх бүхий байгууллагаас	0-8

		<p>авалгүйгээр олгосон болох нь түүний шүүхэд гаргасан "...Өвлөгч П улсын бүртгэлээс надад Б-ийн гэрлэлтийн лавлагаа олгохгүй байна, би хүүтэйгээ нэг хаягт хамт амьдарч байсан, өөр хэн нэгэн хүн хүүгийн өвийг хүлээн авах хүсэлт гаргаагүй тул надад өвлөх эрхийн гэрчилгээ олго гэдэг шаардлага тавьсан. Иймээс би МНТанхимаас ирүүлсэн лавлагаа, өвлүүлэгч Б, өвлөгч П нар нэг хаягт амьдарч байгааг нотолсон хорооны Засаг даргын тодорхойлолт, Б-ийн иргэний үнэмлэх дээрх оршин суугаа газрын мэдээлэл зэрэг баримт болон өв хүлээн авах хүсэлт гаргах нэг жилийн хугацаа өнгөрсөнийг харгалзан П-д өвлөх эрхийн гэрчилгээ олгосон..." гэсэн тайлбараар нотлогдож байгаа.</p> <p>Анхан шатны шүүх Иргэний хуулийн 528 дугаар зүйлийн 528.1, 528 дугаар зүйлийн 528.2, Нотариатын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэгт заасныг үндэслэн С-ийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгохдоо хуулийг буруугаар тайлбарлан, үндэслэлгүй шийдвэр гаргасан гэж үзэж байна.</p> <p>Иргэний хуулийн 520 дугаар зүйлийн 520.1, 520.1.1-д зааснаар 2007 онд төрсөн охин М, 2020 онд төрсөн хүү Э, эхнэр С нар хууль ёсны өв залгамжлагч мөн болно.</p> <p>Нотариатын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д "...Нотариатын үйлдэл дараах төрөлтэй байна...", 25.1.4-т "...өвлөх эрхийн гэрчилгээ олгох..." гэж зааснаар нотариатч өвлөх эрхийн гэрчилгээ олгохыг үйлдлийг хийх эрхтэй байхаар заасан бөгөөд тус хуулийн 43 дугаар зүйлд өвлөх эрхийн гэрчилгээ олгох журмыг нарийвчлан зохицуулсан байна.</p> <p>Хариуцагч өвлүүлэгч Б-ийн төрсөн эцэг П-ийн "...улсын бүртгэлээс гэрлэлтийн лавлагаа олгохгүй байна, би хүүтэйгээ нэг хаягт хамт амьдарч байсан..." гэх худал тайлбар түүнээг нотолсон баримтад үндэслэж өөр хэн нэгэн хүн хүүгийн өвийг хүлээн авах хүсэлт гаргаагүй гэх үндэслэлээр П-д өвлөх эрхийн гэрчилгээ олгосон холбогдох хуулийг зөрчсөн.</p> <p>Нотариатч Н нь Нотариатын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2-т "...нотариатын үйлдэл хийхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, түүний хуулбар, шаардлагатай мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардан авах, холбогдох байгууллагын цахим мэдээллийн санг хууль, журам, гэрээнд зааснаар ашиглах..." гэж заасан эрхийн хүрээнд өвлүүлэгч Б нь эхнэр, хүүхэдтэй эсэх мэдээллийг олж авах ажиллагааг хийгээгүй, мөн хуулийн 21.2.5-д заасан "...нотариатын үйлдэлд холбогдох баримт бичгийн үнэн, зөв эсэхийг хянаж нягтлах..." үүргийн дагуу П-ын гарган өгсөн баримт, иргэний үнэмлэх дэх бүртгэл үнэн зөв эсэхийг нягтлаж шалгаагүй байна.</p> <p>Нотариатч Н нь П-ын гаргаж өгсөн хуурамч тодорхойлолт, баримтыг үндэслэн өвлөх эрхийн гэрчилгээ олгох үйлдэл хийсэн Нотариатын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "...Нотариатч дараахь тохиолдолд нотариатын үйлдэл хийхээс татгалзана: 31.1.1.үйлчлүүлэгчийн баримт бичиг нь хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээнд харшилж байвал..." гэж заасныг зөрчсөн тул мөн зүйлийн 31.3-т заасныг үндэслэн өвлүүлэгч Б-ийн мөнгөн хөрөнгийг түүний</p>
--	--	---

		эцэг П-д олгосон өвлөх эрхийн гэрчилгээнүүдийг хүчингүйд тооцох үндэслэлтэй байна.	
	<b>Гомдлын шаардлагаа буюу давж заалдах шатны шүүхэд гаргаж буй хүсэлтээ тодорхойлсон байдал</b> (ИХШХШтХ-ийн 167 дугаар зүйлийн 167.1 дэх хэсэг)		
3	- гомдлын шаардлага буюу давж заалдах шатны шүүхэд гаргаж байгаа хүсэлтээ даалгаврын өгөгдөлд нийцүүлэн оновчтой зөв тодорхойлсон эсэх (ИХШХШтХ-ийн 167 дугаар зүйлийн 167.1.2 дахь заалт)	<b>Давж заалдах шатны шүүхэд гаргах хүсэлт</b>  Иймд Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн ... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаартай шийдвэрт нэхэмжлэлийг бүхэлд нь хангасан өөрчлөлт оруулж өгнө үү.	0-4

Эх сурвалж: [https://shuukh.mn/single\\_case/35235?start\\_date=&end\\_date=&id=2&court\\_cat=1&bb=1](https://shuukh.mn/single_case/35235?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=1)